

**Аудитын код: САГ-2018/01/СТА-ЗГТС**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261885 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Ахлах аудитор Г.Жавхлан  
Утас: 261628 Цахим хаяг: [javkhlang@audit.gov.mn](mailto:javkhlang@audit.gov.mn)

Аудитор Г.Мөнхчимэг  
Х.Ундрага  
Цахим хаяг: [munkhchimegg@audit.gov.mn](mailto:munkhchimegg@audit.gov.mn)  
[undragakh@audit.gov.mn](mailto:undragakh@audit.gov.mn)

Улаанбаатар хот



## Агуулга

---

Аудитын гэрчилгээ .....	0
1 Аудитын тайлан.....	3
1.1 Оршил.....	3
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
1.5 Дотоод хяналт .....	4
1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	4
1.7 Шилэн дансны мэдээлэл .....	5
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	5
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	5
1.9.1 Биет бус хөрөнгийн талаар.....	5
1.9.2 Зардлын талаар.....	6
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	6
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
2 Менежментийн захидал.....	7
2.1 Биет бус хөрөнгийн талаар.....	8
2.2 Зардлын талаар.....	9
3 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	10
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	13
3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
3.6 Аудитын тайлангийн хавсралт.....	17



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР  
АМЬСГАЛЫН САНГИЙН ЗАХИРАЛ  
Х.ГАНБААТАР ТАНАА

2018.03.23 № 06/815  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\10323SAG40.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.НАРАНЧИМЭГ*



\\10.10.10\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2018\0323SAG40.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 1 АУДИТЫН ТАЙЛАН

### 1.1 Оршил

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Байгаль орчин, уур амьсгалын сангийн захирал Х.Ганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 28-наас 2018 оны 03 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Байгаль орчин, уур амьсгалын санд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Г.Мөнхчимэг, гэрээт аудитор Х.Ундрага нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2018 оны 1 дүгээр сарын 09-ны өдрийн 83 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ

Байгаль орчин, уур амьсгалын сангийн эрхэм зорилго нь Байгаль орчин, уур амьсгалыг хамгаалах, нөхөн сэргээх, баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01 ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

судлан тогтоох, байгаль орчинд үзүүлэх хорт нөлөөллийг багасгах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, олон нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой үр ашигтай зарцуулахад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчин, уур амьсгалын сан санхүүгийн үйл ажиллагаандаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

#### **1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан.

Байгаль орчин, уур амьсгалын сан санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

#### **1.5 Дотоод хяналт**


Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн дотоод хяналт санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

#### **1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Худалбар Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилготой төсвийн баталгаажуулжээ.



Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор урсгал зардалд 2,106.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	2,106.7	1,893.6	213.1
Урсгал зардал	2,106.7	1,893.6	213.1
Бараа үйлчилгээний зардал	2,106.7	1,893.6	213.1
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	2,106.7	1,893.6	213.1
Улсын төсвийн санхүүжилт	2,106.7	1,893.6	213.1

Төсвийн зардлын гүйцэтгэл нийт 1,893.6 сая төгрөг буюу 89.9 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан.

### 1.7 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, уур амьсгалын сангийн Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <https://www.shilendans.gov.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбосон.

Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан.

Тайлант онд Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, шийдвэрийн хуулбар хавсаргаагүй байсан мэдээллийг нөхөж оруулсан байна.

### 1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

### 1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

#### 1.9.1 Биет бус хөрөнгийн талаар

2012 онд худалдан авсан 0.9 сая төгрөгийн үнэтэй биет бус хөрөнгө буюу нягтлан бодох бүртгэлийн програмыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14 дүгээр зүйлийн 14.4.2 -т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх, **01 ЗӨРИЛГҮЙ САНАД ДҮГНЭЛТ**

## 1.9.2 Зардлын талаар

Тайлант онд интернетийн төлбөр болон дотоод томилолтын зардал 9.0 сая төгрөгийг тооцоо үүсгэж бүртгээгүй, 17.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа орлогод авалгүй шууд зардлаар тайлагнасан нь “*Журам батлах тухай*” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар*”-ын 3.10, 4.21 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

## АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2016 оны санхүүгийн тайлангаар 532.0 сая төгрөгийн өр төлбөрөөс 226.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулах төсөв тодотголоор батлагдсан байна. 2017 оны 12 дугаар сарын 22-нд 240.0 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, жилийн эцсийн санхүүгийн тайланд 292.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

### 1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 онд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн байгалийн баялгийн нөөц, байгаль орчин төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл арга хэмжээний хүрээнд батлагдсан 523.6 сая төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар нарийвчлан шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 1.11 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 27.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, менежментийн захидлаар 2 зөвлөмж хүргүүлэв.

### 1.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1,241.5 сая төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

### 1.13 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.


Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2,850.0 сая төгрөгийн нийт зардлын 1 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр тооцлоо.

Төлөвлөлтийн явцад шинж чанартай болон орчин нөхцөлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хэмжээ өөрчлөгдөөгүй болно.

### 1.14 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.





Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

## **2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, уур амьсгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**2.1 БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

2012 онд худалдан авсан 0.9 сая төгрөгийн үнэтэй биет бус хөрөнгө буюу нягтлан бодох бүртгэлийн програмыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14 дүгээр зүйлийн 14.4.2 -т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Биет бус хөрөнгө өөрийн эзэмшилд байхгүй байх, хөрөнгийн ангилал буруу хийгдэх зэрэг эрсдэлтэй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 2.2 ЗАРДЛЫН ТАЛААР

## Тэргүүлэх ач холбогдол №1

### ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд интернетийн төлбөр болон дотоод томилолтын зардал 9.0 сая төгрөгийг тооцоо үүсгэж бүртгээгүй, 17.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа орлогод авалгүй шууд зардлаар тайлагнасан нь “*Журам батлах тухай*” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар*”-ын 3.10, 4.21 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

### Эрсдэлүүд

Батлагдсан төсвөөс гадуур зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчих, зардлыг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байх, баримтын бүрдүүлэлгүй орлого, зарлага хүлээн зөвшөөрөх зэрэг эрсдэлтэй байна.

### ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх.

### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 1 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл <small>/төгрөгөөр/</small>
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>638,947,782.00</b>	<b>5,043,338.00</b>
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>633,838,444.00</b>	0.00
Урьдчилж гарсан зардал	633,838,444.00	0.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,109,338.00</b>	<b>5,043,338.00</b>
Хангамжийн материал	5,109,338.00	5,043,338.00
Аж ахуйн материал	5,109,338.00	5,043,338.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,624,107.59</b>	<b>23,256,365.20</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>15,624,107.59</b>	<b>23,256,365.20</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>15,624,107.59</b>	<b>23,256,365.20</b>
Авто тээврийн хэрэгсэл	0.00	11,409,752.91
Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,140,975.30)
Машин, тоног төхөөрөмж	4,135,000.00	4,135,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(932,166.70)	(1,759,166.74)
Тавилга, аж ахуйн эд хогшил	14,522,200.00	14,522,200.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,100,925.71)	(3,910,445.67)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>654,571,889.59</b>	<b>28,299,703.20</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>532,026,568.00</b>	<b>292,004,278.00</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>532,026,568.00</b>	<b>292,004,278.00</b>
Өглөг	532,026,568.00	292,004,278.00
Бусад өглөг	532,026,568.00	292,004,278.00
Байгууллагад төлөх өглөг	532,026,568.00	292,004,278.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>122,545,321.59</b>	<b>(263,704,574.80)</b>
Засгийн газрын хувь оролцоо	122,545,321.59	(263,704,574.80)
Хуримтлагдсан үр дүн	122,545,321.59	(263,704,574.80)
Өмнөх үеийн үр дүн	122,545,321.59	122,545,321.59
Тайлант үеийн үр дүн	0.00	(386,249,896.39)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>654,571,889.59</b>	<b>28,299,703.20</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 1.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,300,081,481.48</b>	<b>2,463,751,740.73</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>174,074,709.00</b>	<b>177,548,551.91</b>
Нийтлэг татварын бус орлого	174,074,709.00	177,548,551.91
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>11,409,752.91</b>
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	11,409,752.91
Бусад орлого	174,074,709.00	166,138,799.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,895,108,090.00</b>	<b>2,031,625,796.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,895,108,090.00</b>	<b>2,031,625,796.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,895,108,090.00	2,031,625,796.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	230,898,682.48	254,577,392.82
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,090,862,394.44</b>	<b>2,850,001,637.12</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,826,933,229.96</b>	<b>2,454,103,684.30</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,826,933,229.96</b>	<b>2,454,103,684.30</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>91,875,286.00</b>	<b>127,328,774.00</b>
Цалин	83,955,286.00	116,952,074.00
Нэмэгдэл цалин	0.00	3,894,300.00
Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	6,482,400.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,001,300.00</b>	<b>9,978,100.00</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,001,300.00	6,017,620.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	0.00	792,096.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	0.00	990,120.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	0.00	198,024.00
<b>Эрүүл мэндийн даатгалын хураамж</b>	<b>0.00</b>	<b>1,980,240.00</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>89,986,000.00</b>	<b>89,919,000.00</b>
Гэрэл цахилгааны зардал	526,000.00	1,353,600.00
Байрны түрээс	89,460,000.00	88,565,400.00



<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,811,750.00</b>	<b>14,166,174.00</b>
Бичиг хэргийн материал	6,494,350.00	2,634,900.00
Тээвэр, шатахууны зардал	6,651,000.00	5,911,450.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	5,666,400.00	5,619,824.00
<b>Нормативт зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>0.00</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	0.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,552,700.00</b>	<b>9,850,000.00</b>
Урсгал засвар	6,552,700.00	9,850,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,787,400.00</b>	<b>3,744,100.00</b>
Дотоод томилолтын зардал	7,787,400.00	3,744,100.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>1,441,706,593.00</b>	<b>2,086,562,625.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,441,706,593.00	2,086,562,625.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>158,712,200.96</b>	<b>112,554,911.30</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	(6,099,640.00)
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	144,993,941.00	114,877,056.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,718,259.96	3,777,495.30
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>263,929,164.48</b>	<b>395,897,952.82</b>
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>263,929,164.48</b>	<b>395,897,952.82</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	263,929,164.48	395,897,952.82
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>209,219,087.04</b>	<b>(386,249,896.39)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>37,200,000.08</b>	<b>0.00</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	37,200,000.08	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)</b>	<b>(37,200,000.08)</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>172,019,086.96</b>	<b>(386,249,896.39)</b>



### 1.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	0.00	0.00
<b>2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>122,545,321.59</b>	<b>122,545,321.59</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	122,545,321.59	122,545,321.59
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	(386,249,896.39)	(386,249,896.39)
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(263,704,574.80)</b>	<b>(263,704,574.80)</b>



#### 1.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,300,081,481.48</b>	<b>2,452,341,987.82</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>174,074,709.00</b>	<b>166,138,799.00</b>
Нийтлэг татварын бус орлого	174,074,709.00	166,138,799.00
Бусад орлого	174,074,709.00	166,138,799.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,126,006,772.48</b>	<b>2,286,203,188.82</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,895,108,090.00</b>	<b>2,031,625,796.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,895,108,090.00	2,031,625,796.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	230,898,682.48	254,577,392.82
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>2,300,081,481.48</b>	<b>2,452,341,987.82</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,300,081,481.48</b>	<b>2,452,341,987.82</b>
<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,037,090,317.00</b>	<b>2,056,444,035.00</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>91,875,286.00</b>	<b>127,328,774.00</b>
Үндсэн цалин	83,955,286.00	116,952,074.00
Нэмэгдэл	0.00	3,894,300.00
Унаа хоолны хөнгөлөлт	7,920,000.00	6,482,400.00
<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,001,300.00</b>	<b>9,978,100.00</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,001,300.00	6,017,620.00
<b>Тэтгэмжийн даатгалын шимтгэл</b>	<b>0.00</b>	<b>792,096.00</b>
<b>ҮОМШ өвчний даатгалын шимтгэл</b>	<b>0.00</b>	<b>990,120.00</b>
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	0.00	198,024.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	0.00	1,980,240.00
<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>89,986,000.00</b>	<b>89,919,000.00</b>
Гэрэл цахилгааны зардал	526,000.00	1,353,600.00
Байрны түрээс	89,460,000.00	88,565,400.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,833,400.00</b>	<b>14,100,174.00</b>
Бичиг хэрэг	5,516,000.00	2,568,900.00
Тээвэр, шатахуун	6,651,000.00	5,911,450.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,666,400.00	5,619,824.00
<b>Нормативт зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>0.00</b>

ТӨРИЙН АУДИТ УУЛЛАГА  
ЗӨРНИГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	0.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,552,700.00</b>	<b>9,850,000.00</b>
Урсгал засвар	6,552,700.00	9,850,000.00
Томилолт, зочны зардал	7,787,400.00	3,744,100.00
<b>Дотоод албан томилолт</b>	<b>7,787,400.00</b>	<b>3,744,100.00</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>1,666,560,290.00</b>	<b>1,478,815,581.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,666,560,290.00	1,478,815,581.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>144,993,941.00</b>	<b>322,708,306.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	207,831,250.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	144,993,941.00	114,877,056.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>262,991,164.48</b>	<b>395,897,952.82</b>
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>262,991,164.48</b>	<b>395,897,952.82</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	262,991,164.48	395,897,952.82
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



### 1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,106,780,600.00</b>	<b>1,893,667,637.00</b>	<b>213,112,963.00</b>	<b>89.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,106,780,600.00</b>	<b>1,893,667,637.00</b>	<b>213,112.963.00</b>	<b>89.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,106,780,600.00</b>	<b>1,893,667,637.00</b>	<b>213,112.963.00</b>	<b>89.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>90,012,400.00</b>	<b>80,352,402.00</b>	<b>9,659,998.00</b>	<b>89.3</b>
Үндсэн цалин	78,277,300.00	69,975,702.00	8,301.598.00	89.4
Нэмэгдэл	3,894,300.00	3,894,300.00	0.00	100.0
Унаа, болон бусад нөхөн олговор	7,840,800.00	6,482,400.00	1,358.400.00	82.7
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,901,300.00</b>	<b>9,901,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	5,940,820.00	5,940,820.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	792,096.00	792,096.00	0.00	100.0
ҮОМШ өвчний даатгал	990,120.00	990,120.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	198,024.00	198,024.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	1,980,240.00	1,980,240.00	0.00	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>90,981,000.00</b>	<b>89,919,000.00</b>	<b>1,062.000.00</b>	<b>98.8</b>
Гэрэл цахилгаан	2,415,600.00	1,353,600.00	1,062.000.00	56.0
Байрны түрээс	88,565,400.00	88,565,400.00	0.00	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,240,000.00</b>	<b>13,423,504.00</b>	<b>4,816.496.00</b>	<b>73.6</b>
Бичиг хэрэг	5,821,200.00	2,129,750.00	3,691.450.00	36.6
Тээвэр, шатахуун	6,890,400.00	5,911,450.00	978.950.00	85.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,528,400.00	5,382,304.00	146.096.00	97.4
Эд хогшил худалдан авах	10,493,900.00	9,850,000.00	643.900.00	93.9
<b>Урсгал засвар</b>	<b>10,493,900.00</b>	<b>9,850,000.00</b>	<b>643.900.00</b>	<b>93.9</b>
Томилолт, зочны зардал	9,217,800.00	3,574,600.00	5,643.200.00	38.8
Дотоод албан томилолт	9,217,800.00	3,574,600.00	5,643.200.00	38.8
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>1,651,539,400.00</b>	<b>1,478,815,581.00</b>	<b>172,723.819.00</b>	<b>89.5</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,796,900.00	1,478.815.581.00	171,981.319.00	89.6
Даатгалын үйлчилгээ	396,000.00	0.00	396.000.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	0.00	198.000.00	0.00



Тээврийн хэрэгслийн оношилгоо	148,500.00	0.00	148.500.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	226,394,800.00	207,831,250.00	18,563.550.00	91.8
Бараа үйлчилгээний бусад зардал	226,394,800.00	207,831,250.00	18,563.550.00	91.8
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,106,780,600.00</b>	<b>1,893,667,637.00</b>	<b>213,112.963.00</b>	<b>89.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,106,780,600.00</b>	<b>1,893,667,637.00</b>	<b>213,112.963.00</b>	<b>89.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,106,780,600.00	1,893,667,637.00	213,112.963.00	89.9
АЖИЛЛАГСДЫН ТОО	5.00	5.00	0.00	
Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	
Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.00	



**Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>2018.03.23</b>	<b>Аудитын нэр:</b>	<i>2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	<b>Аудитын код:</b>
				<b>САГ-2018/1/СТА-ЗГТС</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<i>Байгаль орчин, уур амьсгалын сан</i>			<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	2012 онд худалдан авсан 0.9 сая төгрөгийн үнэтэй биет бус хөрөнгө буюу нягтлан бодох бүртгэлийн програмыг санхүүгийн тайланд тусгаагүй байна	0.9	Зөвлөмж	Байгаль орчин, уур амьсгалын сангийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Х.Ганбаатар, Г.Одончимэг
2	Тайлант онд интернетийн төлбөр болон дотоод томилолтын зардал 9.0 сая төгрөгийг тооцоо үүсгэж бүртгээгүй, 17.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулахдаа орлогод авалгүй шууд зардлаар тайлагнасан байна	26.8	Зөвлөмж	Байгаль орчин, уур амьсгалын сангийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Х.Ганбаатар, Г.Одончимэг
<b>Дүн</b>		<b>27.7</b>			

